



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах Зам, тээврийн улсын
албаны орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг
томилох тухай


"Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам"-ийн 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгаас хамгаалах Зам, тээврийн улсын албаны орон тооны бус штабын бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед мэдээлэл солилцох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах Зам, тээврийн улсын албаны орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг Штабын дарга (С.Батболд)-д үүрэг болгосугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны "Орон тооны бус штаб, мэргэжлийн ангийг томилох, журам батлах тухай" А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД БӨГӨӨД ГАМШГААС
ХАМГААЛАХ ЗАМ, ТЭЭВРИЙН
УЛСЫН АЛБАНЫ ДАРГА



С.БЯМБАЦОГТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн
А/212 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ГАМШГААС ХАМГААЛАХ ЗАМ, ТЭЭВРИЙН УЛСЫН АЛБАНЫ
ОРОН ТООНЫ БУС ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Штабын бүрэлдэхүүн	Хариуцах албан тушаал
1	Штабын дарга	Төрийн нарийн бичгийн дарга
2	Штабын орлогч	Салбарын хяналтын газрын дарга
3	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан /орон тооны/	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн
4	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Мэдээллийн технологийн хэлтсийн дарга
5	Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан	Сургалт, салбарын шагналын асуудал хариуцсан шинжээч
6	Санхүү, хангалт хариуцсан ажилтан	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
7	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан	Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн
8	Бусад ажилтан	Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга

Салбарын болон гамшгийн нөхцөл байдлын онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулж болно.

ГАМШГИЙН ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Зам, тээврийн хөгжлийн салбарын эрхлэх хүрээний ажил үйлчилгээнд осол гарсан болон аюулт үзэгдэл, гаднын нөлөөлөлтэй халдлагад өртсөнөөс болж гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд /цаашид "онцгой нөхцөл байдал" гэх/ шуурхай мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршинзо.

1.2.Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн захиргааны, аж ахуйн нэгж байгууллага бүр өөрсдийн эрхлэх үйл ажиллагаанд үүссэн онцгой нөхцөл байдлын талаар дээд шатны байгууллагад мэдээлэх, мэдээлэл солилцох ажлыг энэ журмыг баримтлан гүйцэтгэх ба өөрийн байгууллага, салбар, нэгжид дотооддоо энэ талаар мөрдөх журмыг тэдгээрийн дарга, захирал нь батлан мөрдүүлнэ.

1.3.Осол гарсан, аюулт үзэгдэл, гаднын халдлагад өртсөн, гамшгийн онцгой нөхцөл байдалд хүргэж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цагийн байдлын тухай анхны мэдээллийг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нь Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон харьяа байгууллагууд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай өгч, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.

Хоёр. Журмын нэр томьёоны тодорхойлолт

2.1.Энэ журамд эрхэлсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1.“Гамшиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн /цаашид “хуулийн” гэх/ 4.1.1-т ... аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

2.1.2.“Аюулт үзэгдэл” гэж хуулийн 4.1.2-т ... аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

2.1.3.“Осол” гэж гэж хуулийн 4.1.3-т /уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг/ заасныг;

2.1.4.“Аюул” гэж хуулийн 4.1.5-т /хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг/ заасныг;

2.1.5. "Гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж хуулийн 4.1.19-т /гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг/ заасныг.

Гурав. Мэдээлэл солилцох ажиллагаа

3.1. Тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн эрхэлсэн ажил, үйлчилгээний хүрээнд төмөр замын болон усан замын тээврийн хэрэгсэл, иргэний агаарын тээврийн нисэх онгоц, улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх болон аюулт үзэгдэл, гаднын нөлөөлөлтэй халдлагын улмаас авто зам, замын байгууламж, үерээс хамгаалах байгууламж, төмөр замд гарсан сүйрэл, осол, гологдол, салбарын үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж, ус хангамжийн шугам сүлжээ эвдэрч тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтнууд тухайн цагийн байдлын тухай дараах байдлаар харилцан мэдээлэл солилцоно.

3.1.1. Онцгой нөхцөл байдлын анхны мэдээллийг анх хүлээн авсан диспетчер, хариуцлагатай эргүүл, жижүүр болон холбогдох ажилтан нь өөрийн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захиралд, түүний эзгүй тохиолдолд ажлыг нь орлож буй албан тушаалтанд нэн даруй мэдээлэх ба тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дарга нь энэ талаар Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийн холбогдох газрын албан хаагч, даргад утсаар болон албан хэрэгцээнд ашиглаж байгаа цахим сүлжээ /Viber, имэйл хаяг г.м/-гээр тус тус шуурхай мэдээлнэ.


3.1.2. Шуурхай мэдээлэл нь ямар үйл явдал болсон, тухайн онцгой нөхцөл байдал болсон газар, огноо, цаг, үүссэн хохирлын шинж чанар, хэр хэмжээ, зам, тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, хувь хүний нэр, холбогдох утас зэргийг багтаасан байна. Шаардлагатай гэж үзвэл мэдээллийг анх хүлээн авсан жижүүр, хариуцлагатай жижүүр болон холбогдох албан хаагч Онцгой байдлын ерөнхий газрын "Шуурхай бүлэг-105"-д мэдээлж болно.

3.1.3. Яамны харьяа байгууллагын болон чиг үүргийн дагуу мэдээлэл хүлээн авсан яамны газрын дарга нь тухайн мэдээллийг хүлээн авмагц нэн даруй Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад мэдээлж, яаралтай арга хэмжээ авах, шаардлагатай бол Онцгой байдлын ерөнхий газрын "Шуурхай бүлэг-105"-д мэдэгдэн туслалцаа авч хамтран ажиллана.

3.1.4. Анхдагч мэдээллийг эхлэн хүлээн авсан энэ журмын 3.1.1-д дурдсан ажилтан мэдээллийг хүлээн авсан болон түүнийг дамжуулсан утас, албан тушаалтан, өдөр, цагийг тусгай бүртгэлд тэмдэглэж хөтөлнө.

3.1.5. Аж ахуйн нэгж, байгууллага, яамны харьяа байгууллагын болон яамны холбогдох газрын албан хаагч, дарга нь мэдээллийг хүлээн авсан даруй судалж тодотгон онцгой нөхцөл байдлын улмаас үүсэх эрсдэлийг бууруулах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг тухайн орон нутгийн удирдлага, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран шуурхай зохион байгуулахын зэрэгцээ цаг үеийн нөхцөл байдлын талаар Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад цаг тутамд мэдээлэл өгч байна.

3.1.6. Энэ журмын 3.1.1-д зааснаар мэдээллийг хүлээн авсан яамны чиг үүргийн газрын дарга нь Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтанд мэдээлж онцгой нөхцөл байдлын талаар тодорхой бүртгэл хөтлүүлж тухай бүр яамны удирдлага, Штабын бүрэлдэхүүнд танилцуулах ажлыг зохион байгуулна.



3.2.Осол, аюулт үзэгдэл, гаднын нөлөөлөлтэй халдлагын улмаас бүс нутаг, улс орныг хамарсан гамшгийн нөхцөлд Гамшгаас хамгаалах Зам, тээврийн улсын албаны штабын дарга нь Онцгой байдлын ерөнхий газартай харилцан цаашид авах арга хэмжээг болон Засгийн газар, олон нийтэд мэдээлэх ажлыг хамтран зохион байгуулна.

3.3.Аюулт үзэгдэл, гаднын нөлөөлөлтэй халдлагад өртсөн, осол гарсан тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдийн эрх үүргийг биелүүлж, баталсан төлөвлөгөөний дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулна.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэ журмыг зөрчсөн, мэдээлэл саатуулсан, буруу ташаа мэдээлэл өгсөн албан хаагчид түүнийг томилсон албан тушаалтан сахилгын шийтгэл, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

